

**ИРГЭД ХАРИЛЦАН ЗОРЧИХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар /цаашид Хэлэлцэн тохирогч талууд гэнэ/,

харилцааг цаашид хөгжүүлэх, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан-техник, соёлын болон бусад салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх эрмэлзлэлийг удирдлага болгон,

хоёр улсын иргэд харилцан зорчих журмыг боловсронгуй болгохыг эрмэлзэн,

дорхи зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нийтлэг заалт**

Нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрт заасан нөхцөлийн дагуу Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэд хүчин төгөлдөр зорчих бичиг баримтаар тус тусын нутаг дэвсгэрт орж, гарч, дамжин өнгөрч буюу оршин сууж болно.

Хоёрдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрт дурдсан хүчин төгөлдөр зорчих бичиг баримт гэж дор дурдсаныг хэлнэ.

1. Монгол Улсын иргэдийн хувьд:

- дипломат паспорт;
- албан паспорт;
- үндэсний гадаад паспорт;
- хүүхдийн хавсралт;
- Монгол Улсад буцах үнэмлэх.

2. Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэдийн хувьд:

- дипломат паспорт;
- албан паспорт;
- энгийн гадаад паспорт;
- буцах үнэмлэх.

Үндэсний гадаад паспорттай болох хүртэл “БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ИРГЭН” гэсэн дардастай хуучин ЗСБНХУ-ын гадаад паспорт хүчин төгөлдөрт тооцогдоно.

3. Хэлэлцэн тохирогч Талууд зорчих бичиг баримт шинээр хэрэглэх болон мөн түүнчлэн хүчин төгөлдөр бичиг баримтад өөрчлөлт оруулах тухайгаа 30 хоногийн өмнө дипломат шугамаар харилцан мэдэгдэх бөгөөд загварудыг солилцоно.

4. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэний Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчсон бичиг баримт нь эх орондоо буцахад хүчин төгөлдөр байна.

Гуравдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт орох, гарах болон оршин суух асуудлыг энэхүү Хэлэлцээр, хүлээн авагч Талын хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа тэр Талын хууль, дүрэм, түүний дотор гадаадын иргэдэд зориулан тогтоосон бүртгэх, оршин суух, хаягийн хөдөлгөөн хийх болон дамжин өнгөрөх журмыг сахин биелүүлэх үүрэгтэй.

Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт олон улсын болон хоёр талын зорчигчдод нээлттэй хилийн боомтоор орох, гарах буюу дамжин өнгөрч болно. Тэрээр Хэлэлцэн тохирогч Талуудын хүчин төгөлдөр үндэсний хууль тогтоомжийн дагуу шаардагдах баримт бичгийг бүрдүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Албан ба хувийн хэргээр зорчих

Тавдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын хүчин төгөлдөр зорчих бичиг баримт бүхий иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт 90 хоногийн хугацаанд түүний визгүйгээр орж, гарч, оршин суух буюу дамжин өнгөрч болно.

2. Иргэд Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу ажиллахаар эсвэл суралцахаар явахаас бусад тохиолдолд виз авахаас чөлөөлөх нь Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэдэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр ажиллах, суралцах эрхийг олгож буй хэрэг биш.

3. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт 90-ээс дээш хоног байх тохиолдолд визийг урьдчилан авсан байна.

Зургадугаар зүйл

1. Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт визгүйгээр орох, гарах болон оршин суух эрхтэй. Байнга оршин суухаар орж буй иргэд энэхүү Хэлэлцээрт хамаарахгүй.

2. Засгийн газар хоорондын дээрх хэлэлцээрийн заалтад хамаарагдахгүй Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суух бол орох виз авсан байна.

Долдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нутаг дэвсгэрт байрлаж байгаа дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагад ажиллаж буй Хэлэлцэн тохирогч нөгөө Талын ажилтан нар, тэдний гэр бүлийн гишүүд албан үүргээ гүйцэтгэж дуусгах хүртэл хугацаанд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт визгүйгээр орох, гарах, оршин суух эрхтэй.

2. Зорчих улсын нутаг дэвсгэрт эрх бүхий байгууллагад бүртгэлтэй Хэлэлцэн тохирогч хоёр Талын албан ёсны төлөөлөгчийн газрын болон монгол-казахын хамтарсан үйлдвэрийн газрын ажилтан нар албан үүргээ гүйцэтгэх бүхий л хугацаанд Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нутаг дэвсгэрт түүний визгүйгээр орох, гарах, оршин суух эрхтэй.

Наймдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Талын иргэдийн насанд хүрээгүй хүүхэд өөрийн хүчин төгөлдөр зорчих бичиг баримтаар буюу тухайн орны хууль тогтоомжийн дагуу хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчийн хүчин төгөлдөр бичиг баримтад гэрэл зургийг нь нааж хавсаргасан бол тэрхүү бичиг баримтаар энэхүү Хэлэлцээрийн заалтын дагуу зорчиж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад заалтууд

Есдүгээр зүйл

1. Хэлэлцэн тохирогч хоёр Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэдийг нутаг дэвсгэртээ оруулахаас татгалзах буюу оршин суух хугацааг нь богиносгох эрхтэй бөгөөд өөрийн шийдвэрийг тэдэнд тайлбарлах шаардлагагүй.

2. Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нутаг дэвсгэрт түр оршин суугаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнийг өөрийн нутаг дэвсгэрт оруулахаас татгалзсан буюу оршин суух хугацааг нь богиносгосон тохиолдолд түүнийг харьяалах улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газарт тухай бүр нь мэдэгдэж байна.

Аравдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчих бичиг баримтаа үрэгдүүлсэн тохиолдолд тэр тухайгаа орон нутгийн эрх бүхий байгууллагад мэдэгдэх ёстой.

2. Орон нутгийн эрх бүхий байгууллага зорчих бичиг баримтаа үрэгдүүлсэн тухай өргөдлийг нотолсон тодорхойлолтыг уг иргэнд үнэ төлбөргүйгээр олгоно.

3. Уг иргэний харьяалах улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар үрэгдүүлсэн бичиг баримтын оронд хүчин төгөлдөр зорчих бичиг баримтыг шинээр олгоно.

Арван нэгдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Тал энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шаардлагатай үед албан шугамаар мэдээлэл солилцож, зөвлөлдөж байна.

Арван хоёрдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Талын тохиролцсоноор нот солилцох замаар энэхүү Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Арван гуравдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч хоёр Тал /хүн, малын халдварт өвчний голомт, байгалийн гамшиг зэрэг/ онцгой тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн үйлчилгээг хэсэгчлэн буюу бүрэн хэмжээгээр түр зогсоож болно.

2. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал тийм арга хэмжээ авсан болон мөн түүнийг өөрчилсөн тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа аль болохоор урьдчилан, чингэхдээ 24 цагаас хэтрүүлэлгүй дипломат шугамаар мэдэгдэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ **Төгсгөлийн заалт**

Арван дөрөвдүгээр зүйл

1. Энэхүү Хэлэлцээр нь түүнд гарын үсэг зурснаас хойш 30/ гуч/ хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Хэлэлцээрийг тодорхой хугацаагүйгээр байгуулсан бөгөөд Хэлэлцэн тохирогч аль нэг Тал түүнийг цуцлах тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа дипломат шугамаар бичгээр мэдэгдэх хүртэл хүчин төгөлдөр байх болно. Хэлэлцээрийг цуцлах хүсэлтийн тухай Хэлэлцэн тохирогч нөгөө Талын мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 60 /жар/ хоногийн дараа энэхүү Хэлэлцээр хүчингүй болно.

Энэхүү Хэлэлцээрийг Алматы хотноо 1994 оны арван хоёрдугаар сарын 2-ны өдөр монгол, казах, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарах тохиолдолд орос хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

Гарын үсэг

БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ

Гарын үсэг